



АУДИТЫН КОД: САГ-2018/31/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан

Утас: 261628 Цахим хаяг: javkhlant@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан	3
2	Аудитын гэрчилгээ	8
3	Аудитын тайлан.....	10
3.1	Оршил.....	10
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	10
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	11
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	11
3.5	Дотоод аудит.....	12
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	14
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	14
3.9.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	14
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	14
3.9.3	Төсвийн гүйцэтгэлийн талаар	15
3.9.4	Төсвийн гүйцэтгэлийн талаар	15
3.9.5	Төсвийн гүйцэтгэлийн талаар	15
3.9.6	Хөдөлмөрийн дотоод журам	15
3.9.7	Өр, төлбөр	16
3.9.8	Урьдчилж гарсан зардал.....	16
3.9.9	Анхан шатны баримт.....	16
3.9.10	Гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнээгүй талаар	16
3.9.11	Гэрээний биелэлтийг бүтэн жилээр дүгнээгүй талаар.....	17
3.9.12	Санхүүгийн зөрчлийг арилгах арга хэмжээний талаар.....	17
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	17
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	18
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	18
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	18
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	19
3.16	Үр өгөөжийн тооцоолол	19
4	Менежментийн захидал.....	20
4.1	Төсвийн гүйцэтгэлийн талаар	21
4.2	Төсвийн гүйцэтгэлийн талаар	22
4.3	Хөдөлмөрийн дотоод журмын талаар	23



4.4	Өр төлбөрийн талаар.....	24
4.5	Анхан шатны баримт.....	25
4.6	Гэрээний биелэлтийг дүгнэх талаар	26
4.7	Харьяа байгууллагуудад аудитаар илэрсэн зөрчлийн талаар	27
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	28
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	28
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	29
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	30
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	31
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	32
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	35
7	Үндэсний аудитын газраас санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тогтоосон албан шаардлагууд.....	37



2 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1031

танай _____ -ны № _____ -т

「НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ」
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
С.ЧИНЗОРИГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10 20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG21 Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG25.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Нийгмийг даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Нийгмийн даатгалын сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 25-нд хүргүүлж, аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хариуцаж хэрэгжүүлэв.



сарын 04-ний өдрийн 1/611 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын /хуучин нэрээр/ удирдлага Нийгмийн даатгалын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах;
- Нийгмийн даатгалын сангийн төлөвлөлт, орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах;
- Хууль, тогтоомжийн хэрэгжилт, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргаж үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах;
- Байгууллагын хүний нөөцийн бодлогын болон үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;
- Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг, хөдөлмөрийн магадлагаа гаргаж өгөх;
- Эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдад үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх зэрэг болно.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагаас дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 6 зорилтын биелэлтийг 91.5 хувьтай, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 12 арга хэмжээний биелэлтийг 90.9 хувьтай тус тус хэрэгжүүлэн биелэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж ажилласан байна.


Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан болно.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Нийгмийн даатгалын сангийн зүгээс тавьж буй дотоод төрийн аудитын байгууллага

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.



Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 3 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 15 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2009 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Одоогийн байдлаар Азийн хөгжлийн банкны зүгээс хэрэгжүүлж байгаа төслийн санхүүжилтээр “Интер аудит” ХХК нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх, програм хангамжийн ажлыг боловсруулах ажлыг цогцоор хийж байгаа бөгөөд уг ажил 2019 онд дуусаж, 2020 оноос ашиглаж эхлэх төлөвлөгөөтэй байна.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон ахлах аудитор гүйцэтгэлээ.

Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн даатгалын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад удирдлагын зүгээс тавьж байгаа дотоод хяналтын тогтолцоо зохих хэмжээнд ажиллаж байна гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газар /хуучин нэрээр/-ын үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Хяналт, шалгалтын газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны “Аян эхлүүлэх тухай” А/319 дүгээр тушаалаар 2017 онд “Тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах аян”-ны хүрээнд хяналтыг 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд хийж, тайланг нэгтгэн, дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2/1153 тоот албан бичгээр аяны хүрээнд шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, арга хэмжээ авч ажиллах талаар чиглэл хүргүүлж ажилласан байна.

Хүснэгт 1. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	6
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	6
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	58
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо Дүн (сая.төг)
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

		Дүн (сая.төг)	-
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	
		Дүн (сая.төг)	1,934.0

Эх сурвалж: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан

Шалгалтаар хуурамч баримт бүрдүүлсэн, амралт сувиллын зардлыг давхардуулж жилд 2 удаа авсан, тэтгэврийг илүү тогтоож олгосон, нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зэрэг зөрчлүүд илэрч улсын байцаагчийн төлбөрийн акт тогтоогдсон байна.

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд актын барагдуулалт тайлант онд 86.9 хувьтай байна.

Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд системийн хэмжээгээр эрсдэл “бага”, дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын хэмжээг баталсан байна.

Дээрх хуулиар Нийгмийн даатгалын сангийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээг 1,467,962.8 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 1,541,212.7 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардал болон урсгал зардалд 1,907,540.6 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 99.3 хувь буюу 1,890,850.5 сая төгрөг байна.

Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар зардал хэтрээгүй байна.


Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бэлтгэсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа жилийн төсвийн төсөл;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан;
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан;



- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ;
- Санхүүгийн тайлан;
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
- Байгууллагын батлагдсан төсөв зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Булган аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 10 шийдвэр, Орхон аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 11 шийдвэрийг тус тус Шилэн дансанд байршуулаагүй зөрчил илэрч Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын тайланд бичигдэж, холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгсөн байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл


3.9.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын сангийн харьяа 22 төсвийн төвлөрүүлэн захирагч, 3 төсвийн шууд захирагчдын нийт 25 санхүүгийн тайланг аудитад хамруулсан бөгөөд 23 санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт, 2 байгууллагын тайланд итгэл үзүүлсэн байна. Зөрчлийн нэгтгэлээр нийт 150,811.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 22.3 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөр барагдуулах акт, 33,938.3 сая төгрөгийн зөрчилд 16 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 33,612.6 сая төгрөгийн зөрчилд 60 зөвлөмж өгч, 83,238.1 сая төгрөгийн алдаанд санхүүгийн тайланд 5 залруулга хийсэн байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчилд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригтод менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага, өр төлбөр, зардал дансад аудитын 15 горим, нарийвчилсан сорил хэрэгжүүлсэн ба Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын /2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш/ засгийн газрын тогтоолоор шинээр байгуулагдсан/ эмнэлэг, эмийн сан, ралдаан сувилгуудад



шилжүүлсэн мөнгөний анхан шатны баримтыг түүвэрт хамруулан шалгахад нийт 17,552.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт холбогдох 4 албан шаардлага, 7 аудитын зөвлөмжийг хүргүүлэх.

Дээр дурьдсан 4 албан шаардлага, 7 зөвлөмжийг дэлгэрүүлэн доор танилцуулав. Үүнд:

3.9.3 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,907,540.6 сая төгрөгийн нийт зарлагын батлагдсан төсөвтэйгөөс 1,890,850.5 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэтрүүлээгүй боловч үндсэн цалингийн зардлыг 714.3 сая төгрөгөөр, унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 7.8 сая төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын зардлыг 14.9 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 3.3 сая төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлыг 6.2 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 8.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 52.4 сая төгрөгөөр зэрэг нийт 807.5 сая төгрөгөөр зардлын ангиллыг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригтод албан шаардлага өгөх.

3.9.4 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Нийгмийн даатгалын сангийн тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсөв хэсэгт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Мэдээллийн технологийн төв, Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Нийгмийн даатгалын албаны ажилтнуудын орон тоог тусгаж өгөөгүйгээс шалтгаалан нийт ажилтнуудын тоо төлөвлөгөөнөөс 37 ажилтнаар хэтэрсэн, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн тайланд харьяа байгууллагуудын өөрийн орлогыг нэгтгэж төлөвлөсөн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригтод менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.


3.9.5 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Орхон, Сэлэнгэ, Нийслэл дэх Нийгмийн даатгалын хэлтсүүдийн төсвийн гүйцэтгэл батлагдсан төсвөөс нийлбэр дүнгээрээ 10,000.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригтод менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

3.9.6 Хөдөлмөрийн дотоод журам

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын /хуучин нэрээр/ Хөдөлмөрийн дотоод журмын 6 зүйлийн 6.15-д "Ээлжийн амралтын хоорондох хугацаа 9 сараас доошгүй байна...", 6.17-д "Шинээр ажилд томилогдсон, хүүхэд асрах болон удаан хугацааны чөлөө дуусч ажилд томилогдсон ажилтан томилогдсоноос хойш 9 сар, сэлгэн ажиллаж байгаа ажилтан 6 сар түүнээс дээш ажилласан бол ээлжийн амралт авах эрх үүснэ" гэж заасан нь Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 166 дугаар тушаалаар баталсан Ээлжийн амралт олгох заавар, журмын 1 дүгээр хавсралтын 4-т



"Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр нь тооцон олгоно. Ээлжийн амралт олгох ажлын жил нь ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагад анх ажилд орсон өдрөөс эхлэн тооцогдоно. Тухайлбал, ажилтан 1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр нэг байгууллагад ажилд орсон бол түүнд анхны амралтыг 1999 оны 4 дүгээр сарын 15-наас 2000 оны 4 дүгээр сарын 15 хүртэлх нэг ажлын жилийн хугацаанд, дараагийн амралтыг 2000 оны 4 дүгээр сарын 15-наас 2001 оны 4 дүгээр сарын 15-ныг хүртэлх ажлын жилийн хугацаанд гэх мэтчилэн тус тус тооцож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригтод менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

3.9.7 Өр, төлбөр

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 3,777.6 сая төгрөгийн өр төлбөр толилуулсан ба өмнөх оноос 172.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригтод менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

3.9.8 Урьдчилж гарсан зардал

Нийгмийн даатгалын сангийн тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2012 онд хэрэгжсэн "Эрүүл хүүхэд" аяны хүрээнд зарцуулсан хөрөнгийн урьдчилгаа төлбөр 445.9 сая төгрөг одоог хүртэл барагдаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягт зөрчил арилгуулах албан шаардлага өгөх.


3.9.9 Анхан шатны баримт

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд харилцагч байгууллагуудад бүрдэл дутуу анхан шатны баримтаар 2,444.5 сая төгрөг шилжүүлсэн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягт менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

3.9.10 Гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнээгүй талаар

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд Нийслэлийн улсын ба хувийн эмнэлгүүд, эмийн сан, рашаан сувиллуудтай 311 гэрээ байгуулж санхүүжүүлсэн байна. Уг гэрээний гүйцэтгэлд явцын хяналт хийж, хагас жилээр дүгнээгүй нь гэрээний 5.12-т "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, мэргэжилтнүүд хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өмнөх 2 жилийн гэрээний дүн, явцын хяналт дээр үндэслэн тухайн байгууллага дээр хагас жил тутам очиж, хавсралт 2-т заасан хяналт хийж, үнэлгээний хуудсаар дүгнэж, үр дүнг тооцон ажиллана", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэсэн зарцуулдаг тус тус нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягт менежментийн захидлаар аудитын зөвлөмж хүргүүлэх.

3.9.11 Гэрээний биелэлтийг бүтэн жилээр дүгнээгүй талаар

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд байгуулсан 13.2 сая төгрөгийн гэрээний гүйцэтгэлтэй "Хатагтай" эмнэлэг, 40.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй "Манал оточ" эмнэлэг, 22.9 сая төгрөгийн гэрээний гүйцэтгэлтэй "Болор тун" эмийн сан зэрэг байгууллагуудын 77.0 сая төгрөгийн гэрээний биелэлтийг бүтэн жилээр дүгнээгүй нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягт зөрчил арилгуулах албан шаардлага өгөх.


3.9.12 Санхүүгийн зөрчлийг арилгах арга хэмжээний талаар

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Дамдин овогтой Болормаа нь тайлант оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр "Бүсгүй" эмнэлгийн захирал Д.Мөнхцэцэгтэй авлага, өр төлбөрийн үлдэгдэлгүй болон 10.7 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийн дүнтэй хоёр өөр тооцооны үлдэгдлийн баталгаа үйлдсэн байна. Энэхүү зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" зарчим, 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээр дурьдсан санхүүгийн зөрчлийг арилгах талаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуягт албан шаардлага өгөх.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд харилцагч байгууллагуудад шилжүүлсэн мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтыг түүвэрчлэн шалгахад зарим баримтад мөнгөн орлого, зарлагын журналыг дутуу үдэж архивласан ба аудитаар анхан шатны баримтаас ерөнхий журнал руу нийт дүнгээр нь хөөн шалгах боломжгүй байгаа нь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 5.2.5-д "Албан хэрэг, бичиг баримтын нууцыг чандлан хадгалж, бичиг баримтыг стандартын дагуу боловсруулж, албан хэргийг архивт хугацаанд нь шилжүүлж байна" гэж заасныг зөрчсөн нь аудитад хүндрэл учруулав.
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13 өдрийн 344 дүгээр "Агентлаг байгуулах тухай" тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан ба Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлт гарсны дараа авлага, өр төлбөр, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, бараа материал зэрэг санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг салгаж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлэхээр болсон байна.
- Цагдаагийн байгууллагаас шалгаж байгаа хувийн хэвшлийн 6 эмнэлэг, 2 сувилал, 2 эмийн санг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2018 онд гэрээ байгуулахгүй байх жагсаалтад оруулсан байна.
- Мөн цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Нийгмийн даатгалын сангийн 5 чиглэлээрх сангийн орлого, зардалд төрийн аудитын байгууллагын харьяа газрууд аудитын горим сорилыг бүрэн хэрэгжүүлж амжихгүй байгаа учраас эрсдэлийн үнэлгээг сайтар боловсруулан гүйцэтгэлийн эсвэл эрсдэлийн аудит оруулах шаардлагатай байна гэж үзэв.
- Тайлант онд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд хуримтлагдсан авлагын үлдэгдлийг 37.0 тэрбум төгрөгөөр бууруулж ажилласан боловч бэлэн мөнгөний өргөлт буурсан, барилга, уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон,



аж ахуйн нэгжүүдийн орлого буурсан, төсөвт байгууллагуудын санхүүжилт багассан, аж ахуйн нэгжүүд хоорондоо өр авлагын ихээхэн хэмжээний үлдэгдэлтэй байгаагаас авлага нийт дүнгээрээ буураагүй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр, авлага, бараа материал зэргийг тулган баталгаажуулах;
- Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг шалгах;
- Авлага, өр төлбөрийн үлдэгдэл өссөн буурсан эсэхэд шинжилгээ хийх.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 168,363.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын анхан шатны баримтууд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 17,552.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1,330.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах 4 албан шаардлага өгч, 16,222.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 7 зөвлөмж хүргүүллээ.

Нийгмийн даатгалын сангийн харьяа 22 төсвийн төвлөрүүлэн захирагч, 3 төсвийн шууд захирагчдын зэрэг 25 санхүүгийн тайланг аудитад хамруулсан бөгөөд 23 санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт, 2 байгууллагын тайланд итгэл үзүүлсэн байна. Зөрчлийн нэгтгэлээр нийт 150,811.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 22.3 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөр барагдуулах акт, 33,938.3 сая төгрөгийн зөрчилд 16 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 33,612.6 сая төгрөгийн зөрчилд 60 зөвлөмж өгч, 83,238.1 сая төгрөгийн алдаанд санхүүгийн тайланд 5 залруулга хийсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт


Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлага, тус газрын Хяналт шалгалтын газраас тус тус хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 80 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/3436 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Өмнөх аудитаар материаллаг байдлыг 0.2 хувиар тооцсон бөгөөд энэхүү хувийг өсгөх шаардлагагүй гэж үзэж төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нийт зардлын 0.2 хувиар буюу 3,787.5 сая төгрөгөөр тооцсон болно.



Гэвч гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг бүх харьяа газрууд “зөрчилгүй” санал дүгнэлт авсан, мөн аудитын горим, нарийвчилсан сорил хийж гүйцэтгэх ажилбар бага байгаа учраас санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар шинэчлэн тогтоож 37,875.2 сая төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзэв.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад болон харьяа 2 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас итгэл үзүүлсэн, 20 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 3 төсвийн шууд захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн зэргээс дүгнэж үзэхэд аудитын санал дүгнэлтийг өөрчлөх үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Нийгмийн даатгалын сангийн төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,000.0 хүртэлх сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.



4 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын удирдлага, санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Нийгмийн даатгалын сангийн тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсөв хэсэгт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Мэдээллийн технологийн төв, Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Нийгмийн даатгалын албаны ажилтнуудын орон тоог тусгаж өгөөгүйгээс шалтгаалан нийт ажилтнуудын тоо төлөвлөгөөнөөс 37 ажилтнаар хэтэрсэн, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүүгийн тайланд харьяа байгууллагуудын өөрийн орлогыг нэгтгэж төлөвлөсөн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Төсвийн гүйцэтгэл илэрхийлэгдэхгүй байх

НДЕГ-ын дарга Д.Зоригтод ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, бодитой төлөвлөх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

бодитой Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, тайлбар ирүүлсэн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Орхон, Сэлэнгэ, Нийслэл дэх Нийгмийн даатгалын хэлтсүүдийн төсвийн гүйцэтгэл батлагдсан төсвөөс нийлбэр дүнгээрээ 10,000.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэж заасантай нийцэхгүй байна.

НДЕГ-ын дарга Д.Зоригтод ҮАГ-ын зөвлөмж:

Харьяа байгууллагуудын төсвийн тодотголыг үндэслэлтэй батлуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд:

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл бодитой илэрхийлэгдэхгүй байх, Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд материаллаг нөлөө үзүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, тайлбар ирүүлсэн болно.



4.3 Хөдөлмөрийн дотоод журмын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 6 зүйлийн 6.15-д "Ээлжийн амралтын хоорондох хугацаа 9 сараас доошгүй байна...", 6.17-д "Шинээр ажилд томилогдсон, хүүхэд асрах болон удаан хугацааны чөлөө дуусч ажилд томилогдсон ажилтан томилогдсоноос хойш 9 сар, сэлгэн ажиллаж байгаа ажилтан 6 сар түүнээс дээш ажилласан бол ээлжийн амралт авах эрх үүснэ" гэж заасан нь Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 166 дугаар тушаалаар баталсан Ээлжийн амралт олгох заавар, журмын 1 дүгээр хавсралтын 4-т "Ажилтны ээлжийн амралтыг ажлын жилээр нь тооцон олгоно. Ээлжийн амралт олгох ажлын жил нь ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагад анх ажилд орсон өдрөөс эхлэн тооцогдоно. Тухайлбал, ажилтан 1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр нэг байгууллагад ажилд орсон бол түүнд анхны амралтыг 1999 оны 4 дүгээр сарын 15-наас 2000 оны 4 дүгээр сарын 15 хүртэлх нэг ажлын жилийн хугацаанд, дараагийн амралтыг 2000 оны 4 дүгээр сарын 15-наас 2001 оны 4 дүгээр сарын 15-ныг хүртэлх ажлын жилийн хугацаанд гэх мэтчлэн тус тус тооцож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, ажил олгогч ажилтнуудын хооронд маргаан гарах.

НДЕГ-ын дарга Д.Зоригтод ҮАГ-ын зөвлөмж:

Холбогдох хууль эрх зүйн үндэслэлийг судалж, Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, тайлбар ирүүлсэн болно.



4.4 Өр төлбөрийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 3,777.6 сая төгрөгийн өр төлбөр толилуулсан нь өмнөх оноос 172.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, хэрэгжихгүй байх.

НДЕГ-ын дарга Д.Зоригтод ҮАГ-ын зөвлөмж:

Үүссэн өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцаж, тайлбар ирүүлсэн болно.



4.5 Анхан шатны баримт

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд харилцагч байгууллагуудад шилжүүлсэн мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтыг түүвэрчлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу 2,444.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, хэрэгжихгүй байх.

ЭМДЕГ-ын дарга Ч.Алтанхуягт ҮАГ-ын зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлд тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.6 Гэрээний биелэлтийг дүгнэх талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт:

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газраас тайлант онд Нийслэлийн улсын ба хувийн эмнэлгүүд, эмийн сан, рашаан сувиллуудтай 311 гэрээ байгуулж санхүүжүүлсэн байна. Уг гэрээний гүйцэтгэлд явцын хяналт хийж хагас жилээр дүгнээгүй нь гэрээний 5.12-т "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, мэргэжилтнүүд хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өмнөх 2 жилийн гэрээний дүн, явцын хяналт дээр үндэслэн тухайн байгууллага дээр хагас жил тутам очиж, хавсралт 2-т заасан хяналт хийж, үнэлгээний хуудсаар дүгнэж, үр дүнг тооцон ажиллана", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх" гэсэн зарчмуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

ЭМДЕГ-ын удирдлага харилцагч байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг цаг тухайд нь мэдэхгүй өнгөрөх, холбогдох арга хэмжээ авч чадахгүй байх.

ЭМДЕГ-ын дарга Ч.Алтанхуягт ҮАГ-ын зөвлөмж:

Гэрээг хагас жилээр дүгнэж, үр дүнг тооцон ажиллаж хэвших.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцсан болно.



<p>4.7 Харьяа байгууллагуудад аудитаар илэрсэн зөрчлийн талаар</p>	<p>Тэргүүлэх ач холбогдол №2</p>
---	---

ҮАГ-ын ажиглалт:

Нийгмийн даатгалын сангийн харьяа 22 төсвийн төвлөрүүлэн захирагч, 3 төсвийн шууд захирагчдын нийт 25 санхүүгийн тайланг аудитад хамруулсан бөгөөд 23 санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт, 2 байгууллагын тайланд итгэл үзүүлсэн байна. Зөрчлийн нэгтгэлээр нийт 150,811.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 22.3 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөр барагдуулах акт, 33,938.3 сая төгрөгийн зөрчилд 16 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 33,612.6 сая төгрөгийн зөрчилд 60 зөвлөмж өгч, 83,238.1 сая төгрөгийн алдаанд санхүүгийн тайланд 5 залруулга хийсэн байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

НДЕГ-ын дарга Д.Зоригтод ҮАГ-ын зөвлөмж:

Харьяа байгууллагуудад илэрсэн санхүүгийн зөрчлийг арилгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, Төрийн аудитын байгууллагад биелэлтийг тайлагнах.

Дотоод аудитын үйл ажиллагааг боловсронгуй болгох.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцсан болно.



5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,056,270,320.6	1,291,314,055.6
МӨНГӨН ХӨРӨНГӨ	873,285,435.3	1,097,677,977.9
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	57,000,000.0	57,000,000.0
АВЛАГА	122,439,026.4	134,990,085.3
УРЬДЧИЛГАА	2,372,804.3	445,962.1
БАРАА МАТЕРИАЛ	1,173,054.7	1,200,030.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	38,496,335.4	38,846,004.3
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,496,335.4	38,846,004.3
Биет хөрөнгө	38,367,114.4	38,611,837.4
Биет бус хөрөнгө	129,221.0	234,166.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,094,766,656.1	1,330,160,060.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,518,518.7	9,939,118.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,518,518.7	9,939,118.6
Өглөг	3,604,759.6	3,777,691.2
Урьдчилж орсон орлого	6,913,759.1	6,161,427.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,084,248,137.3	1,320,220,941.4
Засгийн газрын хувь оролцоо	1,084,248,137.3	1,320,220,941.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,153,958.6	11,153,958.6
Хуримтлагдсан үр дүн	1,070,026,187.0	1,306,046,084.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,067,991.7	3,020,898.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,094,766,656.1	1,330,160,060.0



5.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,710,417,463.4	2,128,903,109.5
ТАТВАРЫН ОРЛОГО	1,261,837,671.8	1,439,650,402.9
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,261,837,671.8	1,439,650,402.9
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,735,412.7	112,516,591.8
Нийтлэг татварын бус орлого	74,830,120.6	111,666,229.1
Тусламжийн орлого	905,292.1	850,362.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,844,378.9	576,736,114.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,717,567,199.7	1,893,638,004.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,717,567,199.7	1,893,638,004.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,647,822.6	22,237,926.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,256,892.0	14,574,308.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,548,313.4	1,602,084.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,079,210.6	1,115,629.4
Хангамж, бараа материалын зардал	525,775.8	470,796.8
Эд хогшил, урсгал засварын зардал	51,127.5	64,712.2
Томилолт, зочны зардал	106,308.7	126,578.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,655,478.4	1,548,550.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,424,716.2	2,735,266.5
ТАТААС	26,291,029.0	38,114,976.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,669,628,348.2	1,833,285,101.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(7,149,736.3)	235,265,105.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	19,050.1	6,017.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	61,602.1	2,780.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(7,192,288.3)	235,268,342.2

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,092,551,335.3	0.0	1,092,551,335.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,110,145.7)	0.0	(1,110,145.7)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,091,441,189.6	0.0	1,091,441,189.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(764.0)	0.0	(764.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	(7,192,288.3)	0.0	(7,192,288.3)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,084,248,137.3	0.0	1,084,248,137.3
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,084,248,137.3	0.0	1,084,248,137.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	751,554.8	0.0	751,554.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,084,999,692.1	0.0	1,084,999,692.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(47,093.0)	0.0	(47,093.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	235,268,342.2	0.0	235,268,342.2
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,320,220,941.4	0.0	1,320,220,941.4



5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мян.төг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,820,018,462.7	2,120,186,821.9
ТАТВАРЫН ОРЛОГО	1,240,678,858.1	1,432,240,077.8
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,240,678,858.1	1,432,240,077.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,919,437.2	115,398,512.8
Нийтлэг татварын бус орлого	81,919,437.2	115,398,512.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	497,420,167.4	572,548,231.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,725,710,753.7	1,895,793,478.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,725,710,753.7	1,895,793,478.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,998,124.1	21,278,004.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,835,935.5	15,005,467.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,483,888.4	1,652,202.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,076,609.0	1,052,771.6
Хангамж, бараа материалын зардал	452,152.1	425,382.5
Нормативт зардал	0.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	47,829.8	65,576.6
Томилолт, зочны зардал	106,308.7	126,578.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,714,017.7	2,802,677.7
Бараа үйлчилгээний бусад зардал	281,383.0	147,348.6
ТАТААС	27,260,630.4	37,737,855.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,677,451,999.2	1,836,777,618.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	94,307,709.0	224,393,343.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	(77,698,262.0)	0.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	(77,698,262.0)	0.0
Дотоод эх үүсвэрээр	(77,698,262.0)	0.0
Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	77,698,262.0	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	4,252.6	(800.7)
Бусад эх үүсвэр	4,252.6	1,802.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	0.0
ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	2,603.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	172,010,223.6	224,392,542.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	701,275,211.7	873,285,435.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	873,285,435.3	1,097,677,977.9




5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,907,540,611.4	1,890,850,575.7	16,690,035.7	99.1
УРСГАЛ ЗАРДАЛ	1,907,540,611.4	1,890,850,575.7	16,690,035.7	99.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,431,818.7	20,142,344.0	289,474.7	98.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,068,472.6	15,015,185.3	53,287.3	99.7
Үндсэн цалин	12,363,191.1	13,077,473.7	(714,282.6)	105.8
Нэмэгдэл	1,506,993.6	770,888.0	736,105.6	51.2
Унаа хоолны хөнгөлөлт	635,955.7	643,839.2	(7,883.5)	101.2
Гэрээт ажлын хөлс	562,332.2	522,984.5	39,347.7	93.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,664,109.2	1,657,922.1	6,187.1	99.6
Тэтгэврийн даатгал	1,058,978.5	1,054,438.5	4,540.0	99.6
Тэтгэмжийн даатгал	151,283.0	135,949.6	15,333.4	89.9
ҮОМШӨ-ний даатгал	121,025.8	135,949.6	(14,923.8)	112.3
Ажилгүйдлийн даатгал	30,256.4	29,842.6	413.8	98.6
Эрүүл мэндийн даатгал	302,565.5	301,741.8	823.7	99.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,125,303.4	1,087,256.2	38,047.2	96.6
Гэрэл, цахилгаан	207,214.1	210,587.1	(3,373.0)	101.6
Түлш, халаалт	629,336.1	597,121.0	32,215.1	94.9
Цэвэр, бохир ус	85,223.7	77,604.6	7,619.1	91.1
Байрны түрээс	203,529.5	201,943.5	1,586.0	99.2
Хангамж, бараа материалын зардал	430,736.3	427,181.3	3,555.0	99.2
Бичиг хэрэг	121,617.3	120,700.7	916.6	99.3
Тээвэр, шатахуун	138,351.7	138,883.4	(531.7)	100.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	113,690.2	105,199.5	8,490.7	92.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,572.0	6,636.3	935.7	87.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,505.1	55,761.4	(6,256.3)	112.6
Эд хогшил, урсгал засварын зардал	65,982.1	65,634.2	347.9	99.5
Багаж, техник, хэрэгсэл	24,599.6	15,572.5	9,027.1	63.3
Урсгал засвар	41,382.5	50,061.7	(8,679.2)	121.0
Томиллолт, зочны зардал	128,780.5	126,882.1	1,898.4	98.5
Дотоод албан томилолт	128,780.5	126,882.1	1,898.4	98.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,713,729.4	1,623,874.1	89,855.3	94.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	853,744.9	906,201.8	(152,456.9)	106.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	49,230.2	46,669.6	2,560.6	94.8



Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Даатгалын үйлчилгээ	23,527.4	19,524.8	4,002.6	83.0
Тээврийн хэрэгслийн татвар	6,181.6	5,001.8	1,179.8	80.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	431,096.1	431,078.1	18.0	100.0
Газрын төлбөр	11,769.2	9,337.9	2,431.4	79.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	239,180.0	181,615.2	57,564.8	75.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	99,000.0	24,445.0	74,555.0	24.7
Бараа үйлчилгээний бусад зардал	234,705.2	138,408.6	96,296.6	59.0
Бараа үйлчилгээний бусад зардал	96,000.0	1,050.0	94,950.0	1.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	138,705.2	137,358.6	1,346.6	99.0
ТАТААС	42,863,300.0	37,737,855.3	5,125,444.7	88.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	42,863,300.0	37,737,855.3	5,125,444.7	88.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	42,863,300.0	37,737,855.3	5,125,444.7	88.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,844,245,492.7	1,832,970,376.5	11,275,116.2	99.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	269,664,535.7	249,966,254.0	19,698,281.7	92.7
Засгийн газрын дотоод шилжүүлэг	269,664,535.7	249,966,254.0	19,698,281.7	92.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	1,574,580,957.0	1,583,004,122.5	(8,423,165.5)	100.5
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,573,199,505.9	1,581,631,345.1	(8,431,839.2)	100.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	296,319.9	295,957.7	362.2	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	627,331.2	627,331.2	0.0	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	457,800.0	449,488.4	8,311.6	98.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0	0.0	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,907,540,611.4	2,114,238,088.7	(206,697,477.3)	110.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	570,232,387.5	570,232,387.5	0.0	100.0
Улсын төсвөөс санхүүжих	570,232,387.5	570,232,387.5	0.0	100.0
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,337,221,889.5	1,541,212,731.7	(203,990,842.2)	115.3
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,024,420,492.8	1,223,091,163.9	(198,670,671.1)	119.4
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	312,801,396.7	318,121,567.8	(5,320,171.1)	101.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	86,334.4	2,792,969.5	(2,706,635.1)	3,235.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	2,409,242.2	(2,409,242.2)	0.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,334.4	383,727.3	(297,392.9)	144.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	873,285,435.3	(873,285,435.3)	0.0

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,097,677,977.9	(1,097,677,977.9)	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,086.0	3,160.0	(74.0)	102.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО	34.0	34.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	34.0	34.0	0.0	100.0
Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,526.0	1,563.0	(37.0)	102.4
Удирдах ажилтан	42.0	41.0	1.0	97.6
Гүйцэтгэх ажилтан	1,267.0	1,324.0	(57.0)	104.5
Үйлчлэх ажилтан	80.0	75.0	5.0	93.8
Гэрээт ажилтан	137.0	123.0	14.0	89.8
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,526.0	1,563.0	(37.0)	102.4
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,203.0	1,281.0	(78.0)	106.5
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	185.0	155.0	30.0	83.8
Гэрээт ажилтан	138.0	127.0	11.0	92.0

